



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2022 оны II улирлын тайлан



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

Цахим шуудан: nbfi@frc.mn

Зээлийн батлан даалтын сангийн ерөнхий төлөв байдал

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сан байгуулагдсан. Зээлийн Батлан Даалтын Сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зохицуулан ажилладаг. Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу санхүүгийн тайлан, батлан даалтын дэлгэрэнгүй тайлан мэдээг авч, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг мөрдүүлж ажиллаж байна.

2022 оны 2 дугаар улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 258.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буюу 7.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Сангийн өөрийн хөрөнгө 73.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар буюу 5.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. 2022 оны 2 дугаар улиралд нийт орлого 4.9 тэрбум төгрөг ба үүнээс 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.



Зээлийн батлан даалтын сан нь байгуулагдсанаасаа хойш нийт 1106

зээлдэгчид 314.2 тэрбум төгрөгийн зээлд 154.4 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна. 2022 оны 2 дугаар улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сан нь 584 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн 162.3 тэрбум төгрөгийн зээлд 82.7 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй байна. Нийт батлан даалт гаргасан зээлийн 14.2 хувь нь чанаргүй зээл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар, хэвийн зээл нийт зээлийн 82.69 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар тус тус буурсан бол анхаарал хандуулах зээл 3.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд

Зээлийн батлан даалтын сан нь 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 16 төсөл болон банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлд батлан даалт гаргасан байна. Үүнд:

№	Төслийн нэр	Батлан даалтын хэмжээ /төгрөг/	Зээлдэгчдийн тоо
1	Ажлын байрыг дэмжих зээл	28,456,424,392.0	208
2	Аймгийн жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн бизнесийн үйлчилгээг дэмжих сан	49,200,000.0	4
3	Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл	78,797,974,681.0	397
4	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөл	21,000,000.0	2
5	АХБ-ны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл	300,000,000.0	1
6	Барилга, хот байгуулалтын яамны төсөл	250,000,000.0	1
7	Жайка	9,711,521,120.0	56
8	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсөл	7,864,800,700.0	94
9	Монгол 888 төсөл	1,329,045,000.0	10
10	Монсеффийн төсөл	420,000,000.0	1
11	Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан	412,195,400.0	9
12	Органик Монгол хөтөлбөр	3,000,000.0	1
13	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах төсөл /ХХААХҮЯ/	1,626,221,900.0	5
14	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны төсөл /ХХААХҮЯ/	6,933,375,000.0	67
15	Хөгжлийн банк	2,499,900,000.0	1
16	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	161,035,000.0	54
17	Банк	15,455,610,705.6	192
18	Банк бус санхүүгийн байгууллага	97,000,000.0	3

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа

2022 оны 2 дугаар улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сантай нэр бүхий 11 банк, 4 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээтэй бөгөөд үүнээс 6 банк, 1 банк бус санхүүгийн байгууллагаар батлан даалт

гарч байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар батлан даалтын 38 хүсэлт шинээр ирснээс 23 хүсэлтийг гаргахаар шийдвэрлэсэн байна.



Сангийн батлан даалтын үлдэгдэл 2022 оны 2 дугаар улиралд 82.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн байна. Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл нь 162.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өссөн байна.

Нийт 584 зээлдэгчид 82.7 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй байгаагаас 81 зээлдэгчийн 10.3 тэрбум төгрөгийн батлан даалт буюу 12.47 хувь нь чанаргүй байна.

Нийт батлан даалтын дүнд олгосон батлан даалтын 43.8% нь Улаанбаатарт, 56.2% нь орон нутагт олгосон байна. Нийт батлан даалт гаргасан салбараар нь ангилж үзвэл боловсруулах үйлдвэр 35%, бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа 30.3%, хөдөө аж ахуй ан агнуур ойн аж ахуй 8.2%, аялал жуулчлал зочид буудал зоогийн газар 7%, эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар 6.1%-ийг тус тус эзэлж байна.



Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг баталсан бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 385 дугаар тогтоолоор журмын 2.1.5 дахь хэсгийн “1 жилийн” гэснийг “6 сарын” гэж, 2.2.2 дахь

хэсгийн “10” гэснийг “3” гэж, 2.2.3 дахь хэсгийн “10” гэснийг “20” гэж, 3.6.2 дахь хэсэгт заасан “15” гэснийг “20” гэж тус тус өөрчилсөн. “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 385 дугаар тогтоолыг дагаж мөрдөхөөр заасан.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд:

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Тайлангаар	Хангасан эсэх
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Өөрийн хөрөнгийн байвал зохих доод хэмжээ	5'000'000'000	73,964,048,381.72	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	28.57%	Хангасан
Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	82,666,014,629.15	Хангасан
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	107.55%	Хангасан
АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	60.00%	Хангасан
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	3%-аас хэтрэхгүй	4.31%	Хангаагүй
Өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.00%	Хангасан
Урт хугацаат өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.00%	Хангасан
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	1.34%	Хангасан
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.22%	Хангасан
НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт	1,946,331,472.73	11,119,956,518.19	Хангасан
ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	12.47%	Хангасан

Зээлийн батлан даалтын сан нь “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д заасан 12 зохистой харьцааг хангаж ажиллахаас 11-ийг нь хангаж ажилласан байна.

Журмын 2.2.1-т сангийн өөрийн хөрөнгө нь 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгөөс доошгүй мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн байх гэж заасны дагуу 73,9 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэйгөөр зохистой харьцааг хангасан.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 10%-аас доошгүй байна гэж заасны дагуу 28.57 хувьтайгаар зохистой харьцааг хангасан байна.

Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийг 20 нэмэгдүүлснээс хэтрэхгүй зэрэг зохистой харьцааны шаардлагуудыг хангасан байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 100%-аас доошгүй байна гэж заасны дагуу 107.5%-тай хангасан байна.

Журмын 2.2.2-т нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд гаргах батлан даалтын хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэл хувь буюу Сангийн өөрийн хөрөнгийн 3 хувиас хэтрэхгүй гэж заасны дагуу батлан даалтын хэмжээ 60 хувийг хангаж ажилласан. Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 3 хувиас хэтрэхгүй байх гэж заасан боловч 4.31 хувь байгаа нь зохистой харьцааг хангаагүй байна.

Журмын 2.2.7-д үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцохдоо үйл ажиллагааны зардлаас хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг хасч нийт цэвэр хөрөнгөд харьцуулах замаар тооцох ба зохистой харьцаа нь 15 хувиас хэтрэхгүй байна гэж заасны дагуу 1.34%-тай энэхүү харьцааг хангаж ажилласан байна.

Журмын 2.2.5-д цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байна гэсний дагуу 1.22%-тай зохистой харьцааг хангаж ажилласан байна.

Журмын 2.2.9-д Сан нь нөөцийн сантай байх бөгөөд нөөц санг тайлант жилийн цэвэр үр дүнгийн 50-аас доошгүй хувиар байгуулж, батлан даалтын үүргийн гүйцэтгэлийг хангахад зарцуулна гэсний дагуу байвал зохих хэмжээнээс 5.7 дахин их буюу 11.1 тэрбум төгрөгөөр нөөцийн сан байгуулсан байна.

Журмын 3.6.2-т чанаргүй батлан даалтын үлдэгдэл нь батлан даалтын нийт үлдэгдлийн 20 хувиас хэтэрсэн тохиолдолд зээлийн батлан даалтыг хязгаарлах талаар холбогдох шийдвэр гаргана гэж заасны дагуу чанаргүй батлан даалтын үлдэгдэл 12.47 хувь байгаа нь зохистой харьцааг хангаж ажилласан байна.



Чанаргүй батлан даалтын хэмжээ 10.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурч 12.4 хувь болсон байна.



Дүгнэлт, санал

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа хэвийн, зохистой харьцаануудаа хангаж ажиллаж байгаа бөгөөд гаргаж буй батлан даалтын хэмжээг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд тохируулан нэмэгдүүлэх шаардлагатай байна. Зээлийн батлан даалтын сангаас фина системээр ирүүлж буй улирлын тайлан мэдээ нь зөрүүтэй байсан тул тайланг дахин и-мэйлээр авч тоймыг боловсруулсан бөгөөд зайнаас тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээний үнэн зөв байдалд сайтар хяналт тавьж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангуулж ажиллахад анхаарах хэрэгтэй байна. Зээлийн батлан даалтын сантай нэр бүхий 11 банк, 4 банк бус санхүүгийн байгууллага харилцаж байгаа бөгөөд банк бус санхүүгийн байгууллагуудыг Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах шаардлагатай байна. Ингэснээр барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд бизнес эрхлэгчид болон иргэдэд батлан даалт гаргахад банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан зорилтот бүлэгт хүрч ажиллах боломж нэмэгдэнэ. Батлан даалт гаргаж буй эдийн засгийн салбаруудын нийт батлан даалтад эзлэх хувийг өсгөж, салбаруудын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн тайлан, батлан даалтын тайлан мэдээ авах маягтад зарим зүйлийг нэмж тусгах, тайлагналыг сайжруулахад анхаарах хэрэгтэй байна.